



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 77,928,600.00 (далан долоон сая есөн зуун хорин найман мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002015

D:\Huraldaanii material\2018 он\2018.06.19\13docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн  
хавсралт

Дугаар тогтоолын

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСАЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулаалт, арап, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуриимтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод УНЭ (төгрөг)
1	Хьюндай Соната-6 01-68 УБҮ, суудлын, хөдөлгүүр-732004, арап-КМНЕТ41ВР8А472093	2007/2007	147 740	20 310 000,00	20 310 000,00	-	2 000 000,00
2	Хьюндай Соната-6 80-80 УБӨ, суудлын, хөдөлгүүр-8802986, арап-КМНЕТ41АР9А526553	2008/2008	147 000	25 231 600,00	25 231 600,00	-	2 500 000,00
3	Хьюндай Соната -7, 01-44 УНҮ, суудлын, хөдөлгүүр-G4KDAAG628515, арап-КМНЕВ41BBBBVA256493	2010/2010	135 612	32 387 000,00	32 387 000,00	-	3 500 000,00
				77,928,600.00 (далан долоон сая есөн зуун хорин найман мянга зургаан зуун)	77,928,600.00 (далан долоон сая есөн зуун хорин найман мянга зургаан зуун)		8,000,000.00 (найман сая)
		Нийт дүн	-				